


МӨНХЖИМ

ХУВЬЦААТ КОМПАНИ



Хурлын материал

2026.04.21



Хурлын тов:
2026.04.21

Хурал зохион байгуулагдах байршил:
УБ хот, ХУД, 15-р хороо, 29-р байр, 4 тоот

Хурлыг мэдэгдэл



Компанийн нэр:	"Мөнхжим" Хувьцаат Компани
Хаяг, утас:	Увс, Улаангом, 6-р баг, Үйлдвэрлэлийн бааз Утас: 9911-5351, 9509-1109
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 4 сарын 21-ний өдөр, 11:00 цагт
Хурал хуралдах газар:	Улаанбаатар хот, ХУД, 15-р хороо, 29-р байр, 4 тоот
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хуралдах шийдвэр гаргасан огноо:	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 09-ны Т-03/26 дугаар тогтоол
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 03 дугаар сарын 12 2026 оны 03 дугаар сарын 27
Бүртгэх өдөр:	2026 оны 03 дугаар сарын 30
Хурлын материал хүргүүлэх огноо:	2026 оны 03 дугаар сарын 16
Хурлын даргын нэр:	Ц.Цэрэнсамбуу
Тооллогын комиссын бүрэлдэхүүн:	Тооллогын комиссын дарга: С.Санжаа Гишүүн: О. Болормаа

Хурлыг дэг



№	Утга	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:50-11:00
	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	11:00-11:05
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дарга нээх	11:05-11:10
3	Мөнхжим ХК-ийн гүйцэтгэх захирлын ажлын тайлан	11:10-11:20
	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийг	11:30-11:40
	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах	11:40-11:50
	2026 он үйл ажиллагааны төлөвлөгөө	11:50-12:00
	Мөнхжим ХК-ийн газрыг эргэлтэд оруулах түрээслэх хэсэгчлэн зарах туха	12:00-12:10
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	12:20-12:30
	ТУЗ-ийн 2026 оны төсөв батлах	12:30-12:40
4	Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт хариулт	12:40-12:45
5	Саналын хуудсыг бөглөх, санал хураалт	12:45-12:50
6	Хурлын завсарлага	12:50-12:55
7	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах, батлуулах	12:55-13:00
8	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	13:00-13:05
9	Хурлыг хаах	13:05-13:10

2025 оны



Гүйцэтгэх захирлын ажлын тайлан

Эрхэм хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе.

“Мөнх жим” ХК – Компанийн нөхцөл байдал болон хэрэгжүүлсэн арга хэмжээ

2025 оны 2 дугаар сард Увс аймгийн Татварын албанаас “Мөнх жим” ХК-д 2003 оноос хойш хуримтлагдсан татварын өр төлбөрийн талаар албан мэдэгдэл ирүүлсэн. Уг мэдэгдэлд өр төлбөрийг барагдуулахгүй тохиолдолд компанийн зарим объектыг худалдах замаар төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах боломжтойг дурдсан.

Үүний дагуу компанийн удирдлагын зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай хамтран Увс аймгийн Татварын албаны холбогдох албан тушаалтантай уулзалт хийж, татварын өрийг тодорхой хугацаанд барагдуулах талаар тохиролцсон.

Өрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг сэргээж, Төрийн сангийн тайлангийн системд дахин бүртгүүлсэн.
- Компанийн нэр дээр банкны шинэ данс нээж санхүүгийн үйл ажиллагааг хэвийн болгосон.
- Компанийн эзэмшлийн дуусаагүй барилгын худалдах, худалдан авах гэрээ байгуулж, 54 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг компанийн дансанд төвлөрүүлсэн.
- Хуримтлагдсан татварын өрөөс нэн тэргүүнд төлөх шаардлагатай өрийг 3 удаагийн гүйлгээгээр төлж барагдуулсан.

Мөн компанийн өмч хөрөнгө болон талбайн ашиглалтыг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:


- Компанийн хашаанд байсан эвдэрхий барилгын үлдэгдлийг буулгаж, талбайг цэвэрлэсэн.
- Хуучин гараж болон конторын барилгын дээврийн засвар хийж, ус нэвчих асуудлыг шийдвэрлэсэн.
- Компанийн хашаанд 55 самосвал улаан хайрга ачуулж талбайг тэгшлэн нягтруулсан.
- Ачаа буулгах, хүлээн авах терминалын талбайд шаардлагатай 380В цахилгаан татах бэлтгэл ажлын хүрээнд бетон суурьтай 2 шонг суурилуулсан.

Дээрх арга хэмжээний үр дүнд компанийн ачаа буулгах, хүлээн авах терминалын талбайн үндсэн бэлтгэл ажил хангагдаж, үйл ажиллагааг цаашид эхлүүлэх боломж бүрдсэн болно.

2026 оны

Үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Авто граш болон конторт бүрэн засвар хийж, халаалт оруулан ажиллагаанд оруулах
2. Аж ахуйн хашаанд шинэ зах барьж байгуулах ажлыг хөөцөлдөх
3. Татвар болон хувь хүний өрийг барагдуулж дуусах



ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ



Хурлаар хэлэлцэх асуудал

- ➔ Гүйцэтгэх захирлын ажлын тайлан
- ➔ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
- ➔ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
- ➔ 2026 он үйл ажиллагааны төлөвлөгөө
- ➔ Газрыг эргэлтэд оруулах түрээслэх хэсэгчлэн зарах тухай
- ➔ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ➔ ТУЗ-ийн 2026 оны төсөв батлах

Хуралтай холбогдох баримт бичгийг 2026 оны 3 сарын 16-ны өдрөөс 2026 оны 04-р сарын 20-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 0900-1800 цагийн хооронд Компанийн байранд ирж эсвэл харьяалагдах ҮЦК-иас авч танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 04 сарын 20-ны өдрийн 10:00 цагаар тасалбар болгоно.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг доорх утсаар холбогдон авна уу.

Хаяг: Увс, Улаангом, 6-р баг, Үйлдвэрлэлийн бааз
Утас: 9911-5351, 9509-1109



Санхүүгийн үзүүлэлт

Орлого, үр дүн:

Борлуулалтын орлого

10,000,000

Борлуулалтын өртөг

30,218,756

Татварын дараах алдагдал

-45,380,356

Санхүүгийн байдлын гол үзүүлэлт:

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	346,071.54	5,605,072.74
Бусад авлага	-	217,915,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	346,071.54	223,520,072.74
Үндсэн хөрөнгө	637,115,000.00	317,200,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	637,115,000.00	317,200,000.00
Нийт хөрөнгийн дүн	637,461,071.54	540,720,072.74

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Дансны өглөг	-	8,657,600.00
Татварын өглөг	53,478,326.45	36,563,561.54
НДШ-ийн өглөг	-	212,029.20
Бусад богино хугацаат өр төлбөр	54,818,315.00	11,868,315.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	108,296,641.45	57,301,505.74
Өр төлбөрийн нийт дүн	108,296,641.45	57,301,505.74

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Хувьцаат капитал	811,178,300.00	811,178,300.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(282,013,869.91)	(327,759,733.00)
Эздийн өмчийн дүн	529,164,430.09	483,418,567.00

Төлөөлөн удирдах зөвлөл



2026 оны төсөв

	Улирал бүр	Жил
⌵ Хурлын зардал		2,500,000
⌵ Цалингийн зардал	450,000	
⌵ Бичиг хэргийн зардал		250,000

Хурлын саналын хуудас

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн Т-03/26 дугаар тогтоол “Хавсралт-4”

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....
Регистерийн дугаар
Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо

“Мөнхжим” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 11 цагт Улаанбаатар хот ХУД, 15-р хороо, рашд хороолол, 29-р байр, 4 тоот-д танхимын хэлбэрээр зохион байгуулагдах болно.

Дараах хэлэлцэх асуудлуудыг **ЕРДИЙН АРГААР** санал хураана.
Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэнэ.

№	Хэлэлцэх асуудлын нэр	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Мөнхжим ХК-ийн гүйцэтгэх захирлын ажлын тайлан	танилцуулах					
2	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах						
3	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах	Ердийн	Х-01/26				
4	Мөнхжим ХК-ийг 2026 он үйл ажиллагааны төлөвлөгөө		Х-03/26				
5	Мөнхжим ХК-ийн газрыг эргэлтэд оруулах түрээслэх хэсэгчлэн зарах тухай		Х-04/26				
7	ТУЗ-ийн 2026 оны төсөв батлах		Х-06/26				

Хувьцаа Эзэмшигч /Гарын үсэг/

2026 он ... сарын ... өдөр

Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга
Тооллогын Комиссын Гишүүн

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:
.....

Хурлын саналын хуудас

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн Т-03/26 дугаар тогтоол "Хавсралт-4"

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогНэр.....
Регистрийн дугаар
Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо

“Мөнхжим” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 11 цагт Улаанбаатар хот ХУД, 15-р хороо, рашд хороолол, 29-р байр, 4 тоот-д танхимын хэлбэрээр зохион байгуулагдах болно.

Дараах хэлэлцэх асуудлуудыг КУМУЛЯТИВ АРГААР санал хураана
Кумулятив саналын тоо нь таны эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл нийт $100 \times 9 = 900$ кумулятив саналын эрхтэй болно. Та нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй

6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох				
ТУЗ-ийн ердийн гишүүн:		Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Ц.Цэрэнсамбуу	Кумулятив	Х-05/26	
2.	Б.Пушкин			
3.	Ц.Нямсамбуу			
4.	Р.Баасанхүү			
5.	Ц.Баянзул			
ТУЗ-ийн хараат бус гишүүн:				
1.	Б.Билгүүнзул			
2.	Б.Билгүүнзул			
3.	Б.Батбаатар			
4.	Б.Насанжаргал			

Хувьцаа Эзэмшигч /Гарын үсэг/

2026 он ... сарын ... өдөр

Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга

Тооллогын Комиссын Гишүүн

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....

Хурлын саналын хуудас

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн Т-03/26 дугаар тогтоол "Хавсралт-4"

Саналын хуудсыг бөглөх санамж:

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал аа өгнө.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 21-ны өдөр

№ Х-01/26

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд
хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт болон 2026 оны 04 сарын 21-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: / Ц.ЦЭРЭНСАМБУУ /

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 21-ны өдөр

№ Х-02/26

Улаанбаатар хот

Мөнхжим ХК-ийг 2026 он үйл ажиллагааны төлөвлөгөө тухай

Компанийн тухай хуулийн 65.6.7 дахь заалт мөн 2026 оны 04 сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:/ Ц.ЦЭРЭНСАМБУУ /

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 21-ны өдөр

№ Х-03/26

Улаанбаатар хот

Мөнхжим ХК-ийн газрыг эргэлтэд оруулах түрээслэх хэсэгчлэн зарах тухай тухай

Компанийн тухай хуулийн 62.1.10 болон 88.2 дахь заалтуудыг мөн 2026 оны 04 сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

- Мөнхжим ХК-ийн нэр дээрх газрыг эргэлтэд оруулах зорилгоор түрээслүүлэх, мөн түрээслүүлэхтэй холбогдох бүхий л эрхийг-д олгосугай
- Мөнхжим ХК-ийн нэр дээрх газрыг хэсэгчлэн зарж борлуулах, мөн газрыг хэсэгчлэн борлуулахтай холбогдох бүхий л эрхийг-д олгосугай
- Мөнхжим ХК-ийн нэр дээрх газрыг хэсэгчлэн зарж борлуулах, түрээслүүлэх, мөн хэсэгчлэн зарж борлуулах, түрээслүүлэхтэй холбогдох нэмэлт шийдвэр гаргах эрхийг ТУЗ-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА:/ Ц.ЦЭРЭНСАМБУУ /

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 21-ны өдөр

№ Х-05/26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт болон 2026 оны 04 сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралтын дагуу нийт төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:/ Ц.ЦЭРЭНСАМБУУ /

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МӨНХЖИМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 21-ны өдөр

№ Х-04/26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7. дэх заалт болон 2026 оны 04 сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхын санал авсан:

Ердийн гишүүдэд:

1.
2.
3.
4.
5.

Хараат бус гишүүдэд:

1.
2.
3.
4.

-нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА: Ц.ЦЭРЭНСАМБУУ